**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 02 сарын 15 өдөр Дугаар А/12 Улаанбаатар хот

Жуулчин тээврийн зөвшөөрлийг
шинэчлэн олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/469 дүгээр захирамж, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Жуулчны авто тээврийн үйлчилгээний Ерөнхий шаардлага MNS 5231:2003” стандартын шаардлага хангасан, жуулчин тээврийн зөвшөөрөлтэй тээврийн хэрэгсэлд хотын авто замын хөдөлгөөнд дугаарын хязгаарлалтгүй зорчих зөвшөөрөл олгож, гэрээ байгуулахыг жуулчны аюулгүй байдал, тогтоол шийдвэр хариуцсан ахлах мэргэжилтэн /Э.Мөнхзул/-д даалгасугай.

2. Тээврийн хэрэгсэл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагаас гэрээний дагуу зөвшөөрлийн хураамж 5000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд шилжүүлсэн байдалд хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцоож/-д зөвшөөрсүгэй.

3. Жуулчин тээврийн гэрээг шинэчлэх тухай Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2018 оны А/33 дугаар тушаалын 2, 3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Д.БАТСҮХ

5284325 СБТ 8926 1118203502

1150500031